

Ховд аймаг дахь геологи
шинжилгээний “Алтай нэгдэл” ХК
сүүлийн жилүүдэд 1:50 000-ны масштабын
геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын
21 төсөл хэрэгжүүлсэн.

Стратиграфийн хувьд

- Дөргөний талбайд литостратиграфийн 13 нэгжийг мэмбэрийн, 5 интрузив бүрдлийг фаз фацын түвшинд ангилан зурагласан.
- Байцат формацын хурдас археоциатаар нас нь баттай тогтоогдсон доод кембрийн Ичээт формацыг нийцлэг хучиж, дунд-хожуу кембрийн Тогтохыншил бүрдлээр зүсэгддэг гэдгээс өөр насны үндэслэл тогтоох баримт өмнөх судлаачид олоогүй байв.
- Бид энэ формацын шохойжингоос сайтар хадгалагдсан археоциатын олдвор цуглуулсныг Ч.Минжин кембрийн систем доод серийн настай хэмээн тодорхойлсноор Байцат формацын насыг фаунаар анх баталгаажсан бөгөөд дараа нь Я.Ариунчимэг энэ хэсгээс кембрийн фаун цуглуулсан.

- Уст нуурын талбай харьцангуй энгийн геологийн тогтоцтой. Энд бид литостратиграфийн 6 нэгжийг мэмбэрийн, 7 интрузив бүрдлийг фаз, фацын түвшинд ангилан зурагласан.
- Завханы фосфоритын сав газрын дүүрэгт гүехэн устай тэнгисийн шельфийн нөхцөлд хуримтлагдан, субплатформ бүтцийн хучаас үүсгэн тогтсон Цагаан-Олом формацын шохойжингоос бидний цуглуулсан амьтны үлвэрүүдийг ШУА-ийн палеонтологийн төвийн Б.Энхбаатар төрөл, зүйлийн хэмжээнд эдикариагийн цаг үеийнх гэж тодорхойлсноор бид энэ формацын насыг баталгаажуулж, доод кембрийн Баянгол формацын хурдаснаас бидний цуглуулсан амьтны үлдвэрүүдийг Д.Доржнамжаа, Б.Энхбаатар нар зүйл, төрлүүдийн түвшинд тодорхойлж кембрийн системийн атдабан-ботомын стейжид хамааруулсан.

Цагаан-Олом, Баянгол формацуудын хурдаснаас цуглуулсан фауны тодорхойлолт

д/д	Сорьцын				Д.Доржнамжаа, Б.Энхбаатар нарын тодорхойлолт	Формац
	дугаар	тоо	координат			
1	370	5	47°35'53"	96°32'47"	<i>Ramuscyathus tuberculatus Vologdin, 1940</i>	доод кембри Баянгол
2	370/1	1	47°35'53"	96°32'47"	<i>Ramuscyathus foraminosus Fonin</i>	
3	370/2	1	47°35'53"	96°32'47"	<i>Orbicyatus Vologdin, 1940 т өрөлд хамаарах Orbicyatus mongolicus Vologdin 1940</i>	
4	365/10	1	47°36'06"	96°34'35"	<i>Bipallicyatus manifestus A.Zhuravlev</i>	
5	365/10-4	1	47°36'06"	96°34'35"	<i>Pretiosocyathidae rozanov, 1966 овог, Pretiosocyathus subtilis rozanov зүйл</i>	
6	365	3	47°36'11"	96°35'00"	<i>Ichnogenus Helminthoidea Schafhautl, 1851 т өрлийн Helminthoidea cf. miocenica Sacco, 1886 зүйл</i>	
7	365/7	1	47°36'06.7"	96°34'35.5"	<i>Rivuruaceae (meneghini) elenkin, 1916 овог, Renalcis Vologdin, 1932 т өрлийн Renalcis granulatus Korde, 1973 зүйл</i>	
8	365/9	1	47°36'06.4"	96°34'35.3"	<i>Vermiculatus anfractus, 1959 т өрөл</i>	
9	C-10/2	1	47°35'31"	96°34'36"	<i>Pretiosocyathidae rozanov, 1969, Pretiosocyathidae rozanov, 1966, Pretiosocyathus subtilis rozanov 1966 зүйл</i>	
10	1412/1	1	47°36'24.6"	96°35'09"	<i>Radiosus Z.Zhuravleva, 1964 овог Radiosus incertus Yakchin, 1972 зүйл</i>	
11	403/14	1	47°36'53.6"	96°28'57"	тодорхойлох боломжгүй	

АШИГТ МАЛТМАЛЫН ХУВЬД

- Дөргөний талбайд марганецийн 10, молибдений 1, зэс-цайрын 1, зэс-алтны 1, алтны 6, нүүрсний 1 илрэл шинээр илрүүлж, 100 эрдэсжсэн цэг, шлихийн 41, литогеохимийн 148, урсгал геохимийн 91ш сарнилын хүрээ тогтоосны нэг Гээг хайрхан уул орчимын алтны шлихийн сарнилын хүрээ байсан бөгөөд уржнан жил тэнд 1000 гаруй нинжа хэсэг шаваад тарсаныг та бүхэн сонссон байх.
- Уст нуурын талбайд шинээр алтны 2, молибдений 1, молибден-вольфрамын 1, болорын 1 илрэл, 40 гаруй эрдэсжсэн цэг, шлихийн 13, литогехимийн 26, урсгал геохимийн 20 сарнилын хүрээ тогтоосон.

- Баянбулагийн алтны илрэлд үндсэн ашигт бүрдвэр болох алт хүдрийн биетүүдэд жигд бус тархалттай боловч, хүдрийн биетүүд 0.4-6.0м хүртэл өргөнтэй, 900-1400м хүртэл урттай, судалгаа хийсэн зарим хэсэгт алтны агуулга өндөр (16.9г/т хүртэл), алтны тогтоосон баялгийн хэмжээ P2 зэргээр 20844.88кг тул хүдрийн биетүүдийг гүнд нь судлах, участокийн хэмжээнд эрэл-үнэлгээний ажил хийх шаардлагатай хэмээн бид үнэлгээ өгсөн.
- Хайрханы алтны шижирмэг илрэлийн шурфын шугамуудаар судалсан хөндийн 1800м урт, 240м өргөн хэсэгт (12467мг/м³ хүртэл агуулгаар) илрүүлсэн баялгийн хэмжээг P2 зэргээр 710,25кг. гэж тооцон мөн л эрэл үнэлгээний ажил хийх санал дэвшүүлсэн.